



**ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2022 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 16


Бор-Өндөр

**ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ЗӨӨЖ ШИЛЖҮҮЛЭХ,
ТҮР СААТУУЛАХ БАЙР/ХАШАА/ АЖИЛЛУУЛАХЫГ
БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дахь хэсэг, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4 дэх хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/101 дугаар тушаалыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах байр /хашааг/ хууль журмын хүрээнд гэрээ байгуулан ажиллуулах, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/101 дугаар тушаалаар батлагдсан журмыг мөрдөж ажиллахыг Бор-Өндөр хот тохижилт ТБАГУТҮГ-ын дарга Э.Эрдэнэбатад даалгасугай.
2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг дарга П.Чинбатад даалгасугай.

ДАРГА



ДОТГОНЦЭЦЭГ